



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/048/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 260512 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 261883 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
СУДАЛГАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ж.ЧОЙХАНД ТАНАА

2025.03.17 № 07/1097
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн биетээр оршин байхгүй хөрөнгийг санхүү байдлын тайланд тайлагнасан, суутган тооцогчийн үүргээ хэрэгжүүлээгүй, зорилтод түвшний төлөвлөгөө тасарсан зөрчлүүд нь бидний тогтоосон 26.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19-д "суутган төлөгч гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана." гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ нь тайлант онд 3,105.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,054.4 сая төгрөгийн зардал гарган, 51.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Тус үйлдвэрийн газар нь үндсэн дөрвөн чиг үүргийн хүрээнд төсөл хэрэгжүүлж байгаагаас дараах 2 төсөл амжилттай хэрэгжин тайлант онд дуусаж, тайланг НҮБУАӨСК-ын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн байна. Үүнд:

1. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн талаарх Үндэсний дөрөвдүгээр тайлан-илтгэл, Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн нэмэлт хоёрдугаар тайлан боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх” төсөл (NAP)-ийг 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон.
2. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” / MNG-RS-004/ төсөл 2024 оны 7 дугаар сард дуусгавар болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус компанийн хэрэгжүүлж байгаа “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” хэлэлцээрийн хүрээнд Хамтарсан Кредит Олгох Механизмын шугамаар 2024 онд 8 төсөл хамрагдаж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулан кредит тооцогдсон байна.

2024 оны 09 дүгээр сараас дараах 2 төсөл шинээр хэрэгжиж эхэлсэн байна.

- “Монгол орны хүлэрт газрыг удирдах, бэлчээрийн экосистем, нүүдэлчин малчдын амьжиргаа, дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх ” төсөл
- Үндэсний тавдугаар тайлан илтгэл, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн ил тод байдлын 2 жил тутмын нэг, хоёрдугаар тайлан боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл /NC5 BTR1,2/

Бусад асуудал

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	424,355,401.62	1,585,754,596.94
1.1.2	Дансны авлага	53,990,100.00	45,596,647.95
1.1.4	Бусад авлага	17,356,581.00	-
1.1.6	Бараа материал	55,067,619.00	53,132,070.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	30,000,000.00	32,675,010.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	75,997,800.00	75,997,800.00
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	656,767,501.62	1,793,156,124.89
1.2.1	Үндсэн хөрөнгө	78,055,982.96	73,779,835.07
1.2.2	Биет бус хөрөнгө	1,823,682.47	-
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	79,879,665.43	73,779,835.07
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	736,647,167.05	1,866,935,959.96
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	13,195,100.00	1,951,412.98
2.1.1.2	Цалингийн өглөг	26,567,414.00	55,755,000.00
2.1.1.3	Татварын өр	12,551,431.53	4,847,441.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг	11,124,818.00	-
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	361,356,819.99	1,461,183,223.64
2.1.1.13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	424,795,583.52	1,523,737,078.40
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.6	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	424,795,583.52	1,523,737,078.40
2.3	2. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: -төрийн	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	9,220,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	311,851,583.53	333,978,881.56
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	46,296,698.03
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	311,851,583.53	287,682,183.53
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	311,851,583.53	343,198,881.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	736,647,167.05	1,866,935,959.96

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,863,115,318.66	3,083,731,404.69
2	Борлуулалтын өртөг	1,627,768,693.66	2,849,736,432.98
3	Нийт ашиг /алдагдал/	235,346,625.00	233,994,971.71
5	Хүүний орлого	7,930,294.40	8,002,381.78
8	Бусад орлого	825,495,794.00	10,549,486.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	979,246,511.18	198,450,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(9,914.46)	3,584,118.32
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(6,240,182.95)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	89,516,287.76	51,440,775.58
19	Орлогын татварын зардал	8,951,628.77	5,144,077.55
20	Татварын дараах ашиг (алдагдал)	80,564,658.99	46,296,698.03
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	80,564,658.99	46,296,698.03
24	Орлогын нийт дүн	80,564,658.99	46,296,698.03

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	227,267,419.54	227,267,419.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	8,179,855.00	8,179,855.00
3	Залруулсан үлдэгдэл	-	235,447,274.54	235,447,274.54
4	Тайлант үеийн цэвэр ашиг	-	80,564,658.99	80,564,658.99
7	Зарласан ногдол ашиг	-	4,160,350.00	4,160,350.00
9	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	311,851,583.53	311,851,583.53
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	311,851,583.53	311,851,583.53
12	Тайлант үеийн цэвэр ашиг	-	46,296,698.03	46,296,698.03
15	Зарласан ногдол ашиг	-	24,169,400.00	24,169,400.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	9,220,000.00	-	9,220,000.00
17	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	9,220,000.00	333,978,881.56	343,198,881.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	1,600,341,232.05	4,904,273,408.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	537,688,860.00	4,337,158,853.39
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,062,652,372.05	567,114,554.71
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,727,908,331.18	3,703,841,512.88
1.2.1	Ажилчдад төлсөн	491,232,980.00	445,175,725.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	127,199,443.17	147,188,886.46
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,069,900.00	10,529,199.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	94,086,955.84	6,150,000.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	300,000.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	54,427,708.61	69,985,996.93
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,956,591,343.56	3,024,811,705.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,127,567,099.13)	1,200,431,895.22
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,869,258.24	8,002,381.78
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	7,869,258.24	8,002,381.78
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,960,000.00	26,449,800.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	3,960,000.00	26,449,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,909,258.24	(18,447,418.22)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	326,511.23	9,065,984.03
3.1.4	Бусад	326,511.23	9,065,984.03
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	336,425.69	29,651,265.71
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	24,169,400.00
3.2.5	Бусад	336,425.69	5,481,865.71
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,914.46)	(20,585,281.68)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,123,667,755.35)	1,161,399,195.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,548,023,156.97	424,355,401.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	424,355,401.62	1,585,754,596.94

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.1	Үндэсний тавдугаар тайлан илтгэл, хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн ил тод байдлын 2 жил тутмын тайлан илтгэл боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл /NC5 BTR1,2/	674,000.0	657,537.6	16,462.4	97.6
1.2	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх төсөл /NAP/	1,506,464.4	1,507,835.0	(1,370.6)	100.1
1.3	ХКОМ-ын нарийн бичгийн газрын санхүүжилт	85,000.0	69,121.1	15,878.9	81.3
1.4	Чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлэх дэд төслүүд болон бусад орлого	1,082,100.0	837,233.7	244,866.3	77.4
1.5	Монголын хүлэрт газрыг удирдах, бэлчээрийн экосистем, нүүдэлчин малчдын амьжиргааг дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх төсөл	674,000.0	34,140.0	639,860.0	5.1
2	Нийт орлого	4,021,564.4	3,105,867.4	915,697.0	77.2
3	Нийт зардал	3,980,653.9	3,054,426.6	926,227.3	76.7
3.1	Үйл ажиллагааны зардал	3,921,090.0	3,012,657.0	908,433.0	76.8
3.1.1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	778,720.0	593,565.9	185,154.1	76.2
	Үндсэн цалин	778,720.0	593,565.9	185,154.1	76.2
3.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,340.0	75,372.0	21,968.0	77.4
	Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	81,765.6	63,312.5	18,453.1	77.4
	Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	15,574.4	12,059.5	3,514.9	77.4
3.1.3	Байгууллагын тогтмол зардал	65,657.3	40,032.5	25,624.8	61.0
	Ашиглалтын зардал	12,000.0	6,238.0	5,762.0	52.0
	Байрны түрээсийн зардал	53,657.3	33,794.5	19,862.8	63.0
3.1.4	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	40,957.8	19,300.5	21,657.3	47.1
	Бичиг хэрэг	26,568.8	13,228.3	13,340.5	49.8
	Шуудан холбоо	10,146.5	4,752.2	5,394.3	46.8
	Тээвэр /шатахуун/	4,242.5	1,320.0	2,922.5	31.1
3.1.5	Эд хогшил материалын зардал	60,603.9	2,645.5	57,958.4	4.4
	Хангамжийн материал зардал	31,000.0	755.4	30,244.6	2.4
	Программ хангамж хөгжүүлэлт зардал	4,000.0	1,890.2	2,109.8	47.3
	Сэлбэг хэрэгслийн зардал	25,603.9	-	25,603.9	0.0
3.1.6	Томилот, зочны зардал сургалт	1,031,219.8	677,232.2	353,987.6	65.7
	Албан томилот	314,145.0	78,891.6	235,253.5	25.1
	Сургалт, семинарын судалгаа хөгжүүлэлт зардал	717,074.8	598,340.7	118,734.1	83.4
	Бизнес уулзалтын зардал	100,000.0	4,239.9	95,760.1	4.2
3.1.7	Бусад бараа үйлчилгээний зардал	1,846,591.2	1,604,508.3	242,082.9	86.9
	Засвар үйлчилгээний зардал/ тоног төхөөрөмж /	18,000.0	-	18,000.0	-
	Төлбөр хураамж жижиг татвар	2,142.5	1,518.0	624.6	70.8
	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардал	1,006.0	-	1,006.0	-
	Маркетинг, мэдээлэл сурталчилгаа идэвхжүүлэлтийн зардал	18,250.0	10,800.0	7,450.0	59.2

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	1,805,992.7	1,591,737.3	214,255.4	88.1
	Банкны үйлчилгээний зардал	1,200.0	453.0	747.0	37.8
4	Элэгдэл зардал	59,563.9	35,529.5	24,034.5	59.6
5	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	6,240.2	-	-
6	Татварын өмнөх ашиг, алдагдал	40,910.5	51,440.8	(10,530.3)	125.7
7	Цэвэр ашиг (алдагдал)	36,819.4	46,296.7	(9,477.3)	125.7
8	Төсвийн төлбөрт нийт дүн	259,900.6	205,425.8	54,474.7	79.0
9	а/ Орлогын татварт	4,091.0	5,144.1	(1,053.0)	125.7
10	б/ НДШ	186,892.8	144,945.5	41,947.3	77.6
11	в/ Хүн амын орлогын татвар	68,916.7	55,336.2	13,580.5	80.3
13	Төрийн өмчийн ноогдол ашиг	24,169.4	24,169.4	-	100.0
14	Нийт ажиллагсдын тоо	26.0	21.0	5.0	80.8
15	Нийт цалингийн сан	778,720.0	593,565.9	185,154.1	76.2
16	Нэг ажилтны дундаж цалин	2,495.9	2,355.4	140.5	94.4
17	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	-	100.0
18	Нийт хөрөнгө оруулалт	73,778.0	26,449.8	47,328.2	35.9
19	Нийт авлага	40,000.0	131,403.7	(91,403.7)	328.5
20	Нийт өглөг	40,000.0	62,553.9	(22,553.9)	156.4

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз 6.2 сая төгрөгийг үр дүнгийн тайланд тусгалгүй, өмчийн өөрчлөлтөөр тайлагнасан	1	6,240.2	-	-	1	6,240.2	1	6,240.2	-	-	-	-
Дүн	1	6,240.2	-	-	1	6,240.2	1	6,240.2	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 93.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 17.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 76.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Гадаадын иргэнд олгосон 88.2 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний хөлснөөс 17.6 сая төгрөгийн ХХОАТ суутган тооцож, тайлагнаагүй байна.	1	17,645.7	1	17,645.7	-	-	-	-	-	-	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 76.0 сая төгрөгийн хөрөнгө биетээр оршин байхгүй байна.	1	75,997.8	-	-	1	75,997.8	-	-	-	-	-	-	-
Зорилтод түвшний орлогын төлөвлөгөө 915.7 сая төгрөг буюу 22.8 хувиар, нийт зардлын гүйцэтгэл 926.2 сая төгрөг буюу 23.3 хувиар тус тус дутуу гүйцэтгэлтэй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Дүн	3	93,643.5	1	17,645.7	2	75,997.8	-	-	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.